

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРААС
2023 ОНЫ 02 ДУГААР САРД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН

НЭГ: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТЭС

Дотоод ажил:

Аймгийн Засаг даргын Захирамж А 71, Захирамж Б 3, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын Тушаал А 11, Тушаал Б 4 батлагдсан байна. Үүнээс аймгийн Засаг даргын 71 А Захирамжийг албан ёсны цахим хуудсанд байршуулсан. байршуулсан.

Аймгийн Засаг даргын Тамгын газарт 207 албан бичиг ирснээс 11 нь хугацаатай албан бичиг ирж хугацаанд шийдвэрлэсэн. Байгууллагаас 92 явуулсан албан бичиг байна.

Өргөдөл, гомдол, шагнал:

2-р сард иргэдээс аймгийн Засаг дарга, Тамгын газарт хандаж 120 өргөдөл, гомдол ирснээс:

- Бичгээр -44,
- Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах 11-11 төвөөс – 76,
- Аймгийн Засаг даргын Тамгын газрын иргэдийн санал хүсэлт хүлээн авах 7052-11-11 утсаар болон <http://dornogovi.gov.mn/> сайт хаягаар – 4 өргөдөл санал ирсэн байна.

Өмнөх сард хүлээн аваад судлагдаж байсан 19 өргөдөлд хариуг өгч, 24 өргөдөл судлагдаж байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын иргэдийн санал хүлээн авах утсаар 3 иргэний өргөдөл саналыг хүлээн авч судалж шийдвэрлэх хэлтэс албан тушаалтанд шилжүүлсэн байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын иргэдийн санал хүсэлт хүлээн авах 7052-11-11 утсаар 42 санал, лавлагаа хүлээн авч холбогдох албан тушаалтанд дамжуулан, хариуг өгөв.

Хүлээн авсан нийт өргөдөл, гомдлын 80 нь санал, хүсэлт, 4 нь талархал, 36 нь гомдол байв.

Төрийн дээд шагнал алдар цол, одон, медалиар шагнуулахаар нийт 42 иргэний тодорхойлолт материалыг хүлээн авч Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлэв.

Эдгээр нь:

- Ыйййй өөөөй ааааууаа ççòòууёёуу цолоор – 1,
- Õõààèèððèèíí ããââýýàíú óéààí òòããèèí íâííгоор – 4,
- Öýððèèéí ããââýýàíú óéààí òòããèèí íâííгоор -,
- Àèððàí ããââàñ íâííгоор – 21,
- Öýððèèéí ããââýýàíú íâííгоор - ,
- Õõààèèððèèéí òçíáýò ìääàèиар – 16,
- Öýððèèéí òçíáýò ìääàèиар – иргэнийг шагнуулахаар уламжилсан байна.

2023 онд “Алдарт эх” 1, 2 дугаар зэргийн одонгоор шагнагдах эхчүүдийн баримт бүрдүүлэх тухай чиглэл зааварчилгааг сумдад хүргүүлэв.

Аймгийн 2022 оны “Тэргүүний хамт олон”, “Тэргүүний ажилтан”-ны материалыг хүлээн авч Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн 10 хамт олон, 10 иргэнийг 2022 оны аймгийн тэргүүний хамт олон, ажилтнаар шалгаруулав.

Аймгийн Засаг даргын шагналаар шагнуулахаар материал ирүүлсэн 21 иргэний тодорхойлолт материалыг хүлээн авч бүртгэхэд аймгийн Засаг даргын “Жуух”-аар 6 иргэний, “Өргөмжлөл”-өөр 22 иргэний материал ирсэн байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын төрийн болон албаны нууцад хамаарах 1 албан бичгийг явуулж, 1 албан бичгийг хүлээн авч холбогдох албан тушаалтанд шилжүүлсэн.

Гадаад харилцааны чиглэлээр:

Хамтын ажиллагаатай хот мужуудтай хамтран хэрэгжүүлэх ажлуудыг дэмжих тухай албан бичгийг Гадаад хэргийн яаманд хүргүүлсэн.

Турк улсад тохиолдож буй газар хөдлөлтийн улмаас тохиолдож буй гамшигт эмгэнэл илэрхийлсэн албан бичгийг хүргүүлсэн.

Мэдээллийн технологийн чиглэлээр:

Аймгийн ЗДТГ-аас зохион байгуулж буй цаг үеийн мэдээлэлтэй холбоотой 66 мэдээг албан ёсны цахим хуудас болон

Төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны нэгдсэн систем буюу ERP системийг ашиглах заавар зөвлөмжийг 4 байгууллагын 9 албан хаагчид өгч ажилласан.

ХОЁР: ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТЭС:

Аймгийн Засаг даргаас хэлтсийн харьяа агентлагийн дарга нартай 2023 онд хамтран ажиллах гэрээний төслийг бэлтгэн 2023 оны 02 дугаар сарын 12-ны өдөр байгуулж, хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж байна.

2023 оноос хэрэгжиж эхэлж байгаа болон тус онд шинэчлэн батлагдах эрх зүйн актын талаарх мэдээллийг бэлтгэн төрийн албан хаагчдад үе шаттайгаар хүргэж байгаа бөгөөд аймаг, сумын ИТХ-ын ажлын албаны албан хаагчдад сургалтыг 2023 оны 02 дугаар сарын өдөр зохион байгуулав.

Аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газартай хамтран сумдын Засаг даргын Орлогч дарга, Тамгын газрын дарга, Хууль зүйн мэргэжилтэн зэрэг нийт 40 гаруй албан хаагчдад Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, албан тушаалын гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, захиргааны байгууллагын нэхэмжлэлтэй хэрэгт онцгойлон анхаарах талаар сургалт мэдээлэл хүргэж цаашид анхаарах асуудлын талаар чиглэл өглөө.

Сургалтын үр дүнд цаашид хуулийн хугацаанд нь хамтран ажиллаж аливаа зөрчил, хохирлоос сэргийлэх нэгдсэн ойлголтыг өгч, холбогдох албан тушаалтнуудыг мэдээллээр хангав.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Ж.Хунангаар ахлуулсан ажлыг хэсгийг хүлээн авч уулзаж, хүүхдийн эрхийг хангах чиглэлээр мэдээлэл солилцож, Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны болон сургуулиудын дотуур байрны үйл ажиллагааг танилцуулсан.

Аймгийн Цагдаагийн газар, Тагнуулын хэлтэс, хилийн анги байгууллага, Эрдэнэ сум, Замын-Үүд сумын ЗДТГ-тай хамтран Монгол Улсын Ерөнхийлөгчөөс хилийн 0129, 0108 дугаар анги, Замын-Үүд хилийн боомтын үйл ажиллагаатай танилцах ажлын бэлтгэлийг урьдчилан хангаж ажиллав.

Сар шинийн баяртай холбогдуулан архи, түүнээс үүдэн гарч болзошгүй эрсдэл, хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр уриалга гарган аймгийн хэмжээнд түгээн сурталчилсан.

Мөн орон нутагт үйлдэгдэж байгаа гэмт хэрэгт дүн шинжилгээ хийж тус гэмт хэргийг бууруулахад чиглэсэн цахим нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулан ажиллалаа.

Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан аймгийн Засаг даргаар баталгаажуулан нийт сумдад хүргүүлж хэрэгжилтийг хангуулахад анхааран ажиллаж байна.

Дорноговь аймгийн малчдын нэгдсэн зөвлөгөөн зохион байгуулахтай холбогдуулан малчдад эрх зүйн боловсрол олгоход чиглэсэн өврийн дэвтрийг бэлтгэн ажилласан.

Авлигын эсрэг үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөөнд тусгах арга хэмжээний саналыг гарган Авлигатай тэмцэх газарт хүргүүлж баталгаажуулан хэрэгжилтийг хангахаар ажиллаж байна.

ХАСХОМ мэдүүлгийг хуулийн хугацаанд нь аймгийн хэмжээнд мэдүүлж холбогдох тайлан мэдээллийг гарган Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн.

Эрэлхэг хилчин хурандаа Эрдэнэцогтын Халтарын нэрэмжит Цэргийн гавьяаны болон Цэргийн гавьяаны улаан тугийн одонт Хилийн цэргийн 0168 дугаар анги “Хил хамгаалах байгууллагын түүхт 90 жил- Хилчдийн бахархал” сэдвийн дор Хатанбулаг сум дахь төрийн байгууллагын алба хаагчдын дунд хилчдийн алба үйл ажиллагааг таниулах, албанд ашиглагдаж буй ахуй хангалт, техник хэрэгсэлтэй болон Хил хамгаалах байгууллагын түүх, ангийн алдрын тасалгааг танилцуулах өдөрлөгийг зохион байгуулав.

Архивын тасаг:

Архивын тасгийн 2023 оны 02 дугаар сард хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан хэлтсийн даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажилласан.

Архивын ерөнхий газрын 2023 оны сургалтын төлөвлөгөөний дагуу Засгийн газрын 2021 оны 226 дугаар тушаалаар батлагдсан “Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх журам”-ын хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж, Архивын тасагт ирүүлсэн төрийн байгууллагуудын хэвлэмэл хуудасны захиалгыг нэгтгэн, Нийтлэг үйлчилгээний газраар 5 төрлийн хэвлэмэл хуудасны

эхийг стандартын бэлтгүүлэн хянаж, хэвлэх зөвшөөрөл олгосноор 7 төрийн байгууллага, Замын-үүд сумын 5 багийн хэвлэмэл хуудасны зөрчлийг арилгуулав.

Тайлант сард 2 байгууллага, 60 иргэний өргөдөл, хүсэлтийг хүлээн авч архивын үйлчилгээ үзүүлэв. Нийт 1 байгууллага, 22 иргэнд архивын лавлагаа олгосноос малын а дансны лавлагаа-6, цалингийн тодорхойлолт-6, тодорхойлолт 10-ыг тус тус олгосон.

Аймгийн прокурорын газрын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаатай танилцаж, хадгаламжийн нэгж бүрдүүлэх, архивын баримтын хадгалалт хамгаалалтын нөхцлийг сайжруулах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

Аймгийн Засаг даргын 2021 оны А/515 дугаар захирамжаар байгуулагдсан Алтанширээ суманд баригдсан 4 айлын орон сууцны барилга, иргэн Д.Алтантуяагийн худалдаа үйлчилгээний төв, Замын-Үүд сумын Чөлөөт бүсэд баригдсан худалдаа үйлчилгээний төвийн барилгыг байнгын ашиглалтад оруулах улсын комиссын бүрэлдэхүүн ажиллан, 2 барилга объектийн зураг төслийн баримт бичгийг төрийн архив хүлээн авав.

Архивын тасгийн мэдээллийн технологийн ажилтан, цахим сангийн операторчийн сул орон тоог нөхөж, 2 ажилтан авч, ажлыг хүлээлсэн.

Төрийн архивт хөмрөг үүсгэгч 170 байгууллагын дэлгэрэнгүй судалгаа болон төрийн архивын сан хөмрөгийг 2023-2027 онд нөхөн бүрдүүлэх үндсэн болон боломжит эх үүсвэрийн жагсаалтыг шинэчлэн гаргав. Үндсэн эх үүсвэрийн жагсаалтад 149 төрийн байгууллага, 2 төрийн өмчит хуулийн этгээд, боломжит эх үүсвэр төрийн бус -14, хувь хүн -5-ыг оруулсан байна.

Улсын бүртгэлийн хэлтэс:

- Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр- 2539
 - Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр- 91
 - Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр- 638
- Нийт 2007 бүртгэл хөтөлж, үйлчилгээ үзүүлсэн.

Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасаг нь энэ сард нийт 638 мэдүүлэг хүлээн авч зохих үйлчилгээг үзүүлж, үйлчилгээний хураамж 6623657 төгрөг, тэмдэгтийн хураамж 1993322 төгрөг, Үл хөдлөх эд хөрөнгө худалдан борлуулсны татварт 39182770 төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна.

Цагдаагийн газар

Удирдлага зохион байгуулалтын талаар:

Цагдаагийн ерөнхий газрын Тэргүүн даргын 2023 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн А/06 дугаартай “Сар-Шинэ 2023” нэгдсэн арга хэмжээ явуулах тушаал, Нэгдсэн арга хэмжээ явуулах төлөвлөгөөний дагуу Дорноговь аймаг дахь цагдаагийн газрын даргаар салбар төлөвлөгөөг 2023 оны 01 дүгээр сарын 31-ны өдөр батлуулан хэрэгжилтийг ханган ажилласан.

Гэмт хэрэг илрүүлэх, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр:

Дорноговь цагдаа, Замын-Үүд цагдаа FACEBOOK цахим хаягт Хууль зүй дотоод хэргийн сайд, сангийн сайдын 2017 оны А/297, 360 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Иргэд байгууллагаас төлбөртэй мэдээлэл авахад баримтлах үнэлгээний жишиг”-ийн талаарх мэдээллийг бэлтгэн 597 иргэдээс хандалт авсан.

“Сар шинэ-2023” нэгдсэн арга хэмжээний үед гэмт халдлагад өртөж болзошгүй байгууллага, ААН, гудамж талбай, зах, худалдааны төв зэрэг газруудыг тогтоон хяналт тавьж эргүүлийн чиглэлийг тодорхойлон нийт явган эргүүлийн 13 чиглэлд 42 алба хаагч, хөдөлгөөнт эргүүлд 5 чиглэлд 10 алба хаагч нийт 18 чиглэлд 52 алба хаагч үүрэг гүйцэтгэн чиглэл маршрутанд 87 объект, 107 хүн, 200 тээврийн хэрэгсэл шалгаж 15 зөрчил илрүүлэн 1.925.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч 2 иргэнийг шүүхээр баривчлуулж ажилласан. ЗТХ-ийн 8 дугаар бүлэг “Нийтийн өмч, өмчлөх эрхийн эсрэг зөрчил”, 8.6 дугаар зүйл “Хулгайлах” зөрчил 2 бүргэгдэж шийдвэрлэгдсэн байна.

Орон нутгийн зах, дэлгүүр, худалдааны төв, гэр хороололд стандартын шаардлага хангахгүй, хямд үнэтэй, шошго, хаяг тодорхойгүй согтууруулах ундаа худалдан борлуулдаг цэг, иргэн, айл өрх, ААН-ийн талаар мэдээ, мэдээлэл цуглуулж, илрүүлэн, таслан зогсоох чиглэлээр үзлэг шалгалтыг хийж 2 иргэнээс шошго, хаяг тодорхойгүй 34 шил виски архийг хураан авч 2 иргэнийг 600.000 төгрөгөөр арга хэмжээ авч ажилласан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар:

Цагдан хорих байрны талаар:

Хоригдогч, хоригдлын дундаас гарч болзошгүй гэмт хэрэг, зөрчил дутагдлаас урьдчилан сэргийлэн ажиллаж үзлэг, нэгжлэгийг тогтмол хугацаанд чанартай зохион явуулан ажилласан.

Цагдан хорих байрны үйл ажиллагаа цагийн хуваарийн дагуу хэвийн явагдаж ямар нэг гэмт хэрэг, зөрчил дутагдалгүй байна.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны чиглэлээр:

2022 оны эхний үлдэгдэл 289 гүйцэтгэх баримт бичгийн 3152398,2 төгрөгийн төлбөр дээр шинээр шүүхээс 494888,4 төгрөгийн үнийн дүнтэй 84 гүйцэтгэх баримт бичиг, түдгэлзүүлснийг сэргээсэн 3180,9 төгрөгийн үнийн дүнтэй 1 гүйцэтгэх баримт бичиг хүлээн авч, ахлах шийдвэр гүйцэтгэгчийн тогтоолоор 29014,3 төгрөгийн үнийн дүнтэй 1 гүйцэтгэх баримт бичгийг түдгэлзүүлж, нийт гүйцэтгэвэл зохих 3621453, төгрөгийн үнийн дүнтэй 373 гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж 78637,8 төгрөгийн үнийн дүнтэй 32 гүйцэтгэх баримт бичгийг дуусгавар болгож, 58101,7 төгрөгийн үнийн дүнтэй 52 гүйцэтгэх баримт бичигт хэсэгчилсэн төлөлт хийж тайлант хугацааны эцэст 3484713,8 төгрөгийн үнийн дүнтэй 340 гүйцэтгэх баримт бичгийн үлдэгдэлтэй ажилласан.

Тайлант гүйцэтгэлийн бодит биелэлтийн дундаж 15,8 хувьтай байна.

Хүүхдийн тэтгэлгийн төлбөр барагдуулалтын талаар:

2022 оны эхний үлдэгдэл 292432,3 төгрөгийн үнийн дүнтэй 265 гүйцэтгэх баримт бичиг дээр шинээр 20897,1 төгрөгийн үнийн дүнтэй 6 гүйцэтгэх баримт

бичиг хүлээн авч, гүйцэтгэвэл зохих 313329,4 төгрөгийн үнийн дүнтэй 271 гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж 54 гүйцэтгэх баримт бичгийн 24052,4 төгрөгийг хэсэгчлэн биелүүлж, тайлант хугацааны эцэст 289277,0 төгрөгийн үнийн дүнтэй 271 гүйцэтгэх баримт бичгийн үлдэгдэлтэй байна.

Тус газар нь 2023 оны 02 сарын 28-ны өдрийн байдлаар 15 иргэн 27 хуулийн этгээдэд өр төлбөргүй лавлагааг олгон ажилласан байна.

Онцлох ажлууд:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Шийдвэр гүйцэтгэх албанаас Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд “Хуулиа дээдэлж, үүргээ биелүүлье” “Хүүхдийн тэтгэлэг-хүүхдийн ирээдүй” сэдэвт аянд нэгдэж аяны үйл ажиллагааг сурталчилсан самбар, зурагт хуудаснуудыг бэлтгэн иргэд, олон нийтийн цахим сүлжээнд Дорноговь аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын болон бусад холбогдох төрийн байгууллагуудын цахим хуудсанд байршуулан олон нийтэд сурталчлан ажилласан.

Тус аймгийн Сайншанд сумын төв замын төв уулзвар, хамгийн их зорчигчтой бүсэд 3*6 хэмжээтэй самбар бэлтгэн байршуулж нээлттэй утас зарласны дагуу аяны хугацаанд нийт давхардсан тоогоор 68 иргэний асуултад утсаар мэдээлэл зөвлөгөө өгсөн.

Аяны хугацаанд хүүхдийн тэтгэлэг, шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой өргөдөл гомдол хүлээж аваагүй бөгөөд цаашид энэхүү самбарыг тогтмол байршуулж иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой мэдээлэл уриалга гаргаж ард иргэдэд хүргэж байхаар самбар түрээслүүлэгч байгууллагатай гэрээ байгуулсан.

Дорноговь аймгийн Прокурорын газартай хамтран Зөрчлийн хууль болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн холбогдох зүйл заалтыг практикт хэрхэн хэрэгжүүлэх, шүүхийн шийдвэрийн дагуу төлвөл зохих хүүхдийн тэтгэлэгээ 3 сараас дээш хугацаагаар төлөөгүй хуримтлал үүсгэсэн тэтгэлэг төлөгчид холбогдуулан зөрчлийн хэрэг үүсгэхэд анхаарах зарим асуудлын талаар сургалт хэлэлцүүлэг зохион байгууллаа.

ГУРАВ. НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТЭС

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Монголын уламжлалт сар шинийн баяр амралтын өдрүүд тохиосонтой холбоотой нэгдсэн эмнэлгүүд өрх сумын эрүүл мэндийн төвүүдэд зөвлөмж хүргүүлж, анхан шатны эмнэлгүүд эмийн сангуудыг баярын өдрүүдэд ажиллуулж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллалаа. 2023 оны 02 сарын 20-27-ны өдрүүдэд нэгдсэн болон сумын эрүүл мэндийн төвүүд яаралтай тусламж үйлчилгээг 24 цагаар, өрхийн эрүүл мэндийн төвүүд 11-16 цаг хооронд ажиллаж, нийт 2237 үйлчлүүлэгчид тусламж үйлчилгээ үзүүлснээс түргэн тусламжийн дуудлага-437 хүлээн авч тусламж үзүүлснээс хүүхдийн дуудлага-159 байна. Мөн хугацаанд 8 эх амаржиж 8 нярайг эсэн мэнд эх барьж авсан.

Дорноговь аймгийн сумын эрүүл мэндийн төвүүдийн 2023 оны хэрэгцээт эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах тендерт 24 багцад 13 Эм ханган нийлүүлэх ХХК-ууд тендерийн материал ирүүлэн үнэлгээг хийв. 18 багцад хамгийн сайн үнэлэгдсэн 9 ЭХН ХХК-ууд шалгарч, гэрээг байгуулав. Мөн 8 багцад Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөө бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу дахин тендер зарлав.

ЭМГ-ын даргын 2023 оны А/05 дугаар тушаалаар анхан шатны эмнэлгүүдийн залуу эмч нарыг АНЭ-ийн хүүхдийн тасагт хуваарийн дагуу дадлагажуулж, 02 сард 8 их эмч, 5 сувилагч ажлын байрны дадлагажих сургалтанд хамрагдан чадавхжив

Магадлан итгэмжлэлийн бэлтгэл ажлыг хангах, 11 ЭМБ-уудын дарга, удирдлагын багийг мэргэжил арга зүйгээр хангах сургалтыг зохион байгуулж, 40 хүнийг хамруулав

Алтанширээ, Дэлгэрэх сумын ЭМТ-үүдэд эх барих, эмэгтэйчүүд, цус цусан бүтээгдэхүүний тусламж үйлчилгээнд дэмжлэгт үнэлгээг хийж мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгөв.

Тусгай зөвшөөрөл олгох комиссын 2-р хурлыг хийж, 3 асуудлыг хэлэлцэж, шийдвэрлэсэн. Тусгай зөвшөөрөл олгоход баримтлах чиглэл тогтооход шаардлагатай судалгаа хийх ажлын хэсгийг 11 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, батлуулсан. Тусгай зөвшөөрлийн олгох асуудлаар хамтран ажиллах 4 шинжээчийг сонгон шалгаруулж ЭМГ-ын даргын 2023 оны А/28 тушаалаар баталгаажуулсан.

Мобайл технологийг идэвхжүүлэх зорилгоор сумдын эмч нарыг АНЭ-ийн Дүрс оношилгооны кабинетэд ЭХО-үзлэгийн ажлын байрны дадлагажих сургалтанд хамруулж байгаа бөгөөд 02 сарын байдлаар 4 их эмч сургалтад хамрагдсан.

Мишээлт мана, Талст зам өрхийн эрүүл мэндийн төвүүдийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийж, арга зүйн заавар чиглэлийг хугацаатай өгч, эргэн шалгаж, үйл ажиллагаанд дэмжлэгт хяналт хийв.

АНЭ-ийн хүүхэд, төрөх, нярайн тасагт ажлын хэсгээр дэмжлэгт хяналт хийж, тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэж, үйл ажиллагаанд анхаарах асуудлаар ЭМГ-ын даргын 2023 оны 157 тоот зөвлөмжөөр хугацаатай үүрэг даалгавар өгч, арга зүйгээр ханган ажиллаж байна

"ХҮҮХЭД-АЮУЛГҮЙ ОРЧИН" аяны хүрээнд Сайншанд сумын 3,4,5,6,8,9,10,11,12 дугаар цэцэрлэгийн эцэг эх, асран хамгаалагч нарын 229 төлөөлөлд Хүүхдийг осол гэмтлээс сэргийлэх талаар сургалт зохион байгуулсан.

Сонгинохайрхан нэгдсэн эмнэлгийн хүүхдийн эрчимт эмчилгээний эмч Б.Мягмарсүрэнтэй хамтран сургуулийн эмч, эрүүл мэндийн хичээлийн багш, цэцэрлэгийн эмч, багш нийт 28 байгууллагын 69 хүнд "Томуу, томуу төст өвчин" сэдвээр цахимаар сургалт зохион байгуулсан.

Сумдын ерөнхий боловсролын сургуулийн 8-12 дугаар ангийн хүүхдүүдэд "Нөхөн үржихүйн эрүүл мэнд" сэдвээр цахим сургалтын хуваарийг ЭМГ-ын даргаар батлуулан Айраг, Алтанширээ, Даланжаргалан, Эрдэнэ, Зүүнбаян, Хатанбулаг, Өргөн ЕБС-ийн 8-9 дүгээр ангийн 260 сурагчдад сургалт зохион байгуулсан.

АШИУС-ийн харьяа Био-Анагаахын хүрээлэнгээс зохион байгуулсан □□”Цус төрөл ойртсон гэр бүлийн өвчлөлийн байдлыг тодорхойлох” судалгаанд хамрагдах иргэдийн хуваарийг гарган судалгаанд хамруулсан. 2 сарын 06-11 ны хооронд АНЭ, АШУҮИС-ийн Дорноговь аймаг дахь Анагаах Ухааны сургууль, Политехник коллеж, Мишээлт Мана өрхийн эрүүл мэндийн төвтэй хамтран “Зөв мэдлэг, дадалтай-Эрүүл оюутан” оюутан залуусын эрүүл мэндийг дэмжих аяны удирдамжийг ЭМГ-ын даргаар батлуулан 2023 оны 02 дугаар сарын 16-17 ны өдрүүдэд Политехник коллежийн 2-р курсийн нийт 135 оюутнуудыг нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, шинжилгээнд хамруулсан. Үзлэгт Чих хамар хоолойн өөрчлөлттэй 40, Харааны өөрчлөлттэй 44 оюутныг илрүүлж 2 дахь шатлалд илгээсэн.

Прокурорын газрын хамт олонд Нийгмийн эрүүл мэнд, халдварт бус өвчлөлөөс сэргийлэх, эрүүл зохистой хооллолт сэдвээр сургалт зохион байгуулж 15 хүн хамрагдсан

БШУГ-тай хамтран Үдийн хоолны тогооч нарын хүүхдийн хоолны сургалт, уралдаан зохион байгуулж 41 тогоочийг хамруулсан.

2022 оны 05 сараас эхэлсэн эрүүл мэндийн “Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, шинжилгээ оношилгоо”-нд аймгийн хэмжээнд 20238 иргэн хамрагдсан нь хамрагдвал зохих хүн амын 28.1%-ийг эзэлж байна. Хамралтын байдлыг насны ангиллаар авч үзвэл:

- 70.0% (14158)-ийг 0-17 насны хүүхэд,
- 30.0% (6080)-ийг 18-аас дээш насны хүн ам байна.

2023 оны 02 сард Иххэт, Мандах, Өргөн сумдын нийт 120 иргэнийг үзлэгт хамруулсан.

ХӨСҮТ-ийн тархвар судлалын нийгэмлэгтэй хамтран халдвар судлаач, халдвартын эмч нар, томуугийн харуулдан тандалтын эмч нарт танхимын 2 өдөр сургалт зохион байгуулсан.

МСЭМХ, Эрүүл мэндийн газар, аймгийн нэгдсэн эмнэлэг, Замын-үүд сумын нэгдсэн эмнэлэг, Замын-үүд сумын Борхойн наран эрүүл мэндийн төвтэй хамтран Замын-үүд суманд сүрьеэгийн хавьтлын дунд сүрьеэгийн эрт илрүүлгийн үзлэгийг зохион байгууллаа. Мөн Замын-үүд сумын сүрьеэгийн диспансерийн үйл ажиллагаанд дэмжлэгт хяналтыг хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

Талст зам ӨЭМТ, Алтанширээ, Дэлгэрэх сумдуудад ажлын хэсгээр дэмжлэгт хяналт хийж арга зүйн заавар чиглэл өгөв

Аймгийн нэгдсэн эмнэлгийн халдварт, сүрьеэгийн тасаг, БЗДХ-ын кабинетийн эмч мэргэжилтнүүдэд 2022 оны халдварт өвчний статистик мэдээлэл танилцуулан ажлыг дүгнэж, цаашид авч хэрэгжүүлэх ажлын талаар уулзалт ярилцлага зохион байгуулсан

Чандмань илч ХХК-ийн 76 ажилтан албан хаагчдад “Томуу томуу төст халдвараас сэргийлье”, “Томуугийн болон В вирусийн эсрэг вакцины тухай” мэдээлэл хийсэн

JCI Их хүрээ салбар байгууллагаас “Амьдрал бэлэг” төслийн хүрээнд элгээ хайрладаг хүн бүрт зориулсан тусгай сургалтыг 02 сарын 14-ний өдөр зохион байгууллаа.

Эрдэнэ, Зүүнбаян, Хатанбулаг, Өргөн сумдын ЕБС-ийн 8-9 дүгээр ангийн 127 сурагчдад Нөхөн үржихүйн эрүүл мэнд сэдвээр сургалт зохион байгуулсан.

УБТЗ-ын өртөө зөрлөгийн эмч нарт ЭМБ-уудын халдвартай хог хаягдлыг ялган ангилах, цуглуулах, устгах талаар сургалтыг зохион байгуулсан.

Алтанширээ, Дэлгэрэх сумдад дэмжлэгт хяналт хийж халдварын сэргийлэлт хяналт, дархлаажуулалтын үйл ажиллагаатай танилцаж арга зүйн зөвлөгөө өглөө. Дэлгэрэх, Алтанширээ сумдын Эрүүл мэндийн зөвлөлийн 20 гишүүдэд чадавжуулах сургалт зохион байгуулж, салбар зөвлөлийн ажиллах журам, төлөвлөлт ицхийх арга зүйгээр хангасан. Дэлгэрэх сумын Малчдын зөвлөгөөнд ХБӨ, Хорт хавдраас урьдчилан сэргийлэх, Эрт илрүүлэг үзлэгийн ач холбогдлын талаар 50 гаруй хүнд мэдээлэл өгч, ярилцлага хийлээ.

ХӨСҮТ-өөс 2023 оны 1-р улирал хэрэглэх 11 энэ төрлийн 9,0 сая төгрөгийн вакцин дагалдах хэрэгслийг татан авч сум өрхийн эрүүл мэндийн төвүүдэд тарааж байна.

Агатова, Мишээлт мана өрхийн эрүүл мэндийн төвийн дархлаажуулалтын нэгжид дэмжлэгт хяналт хийж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж ажилласан.

Аймгийн Нэгдсэн эмнэлгээс арчдасын шинжилгээг 2 удаа авч шинжилгээний хариуд дүн шинжилгээ хийсэн.

СОЁЛ УРЛАГИЙН ЧИГЛЭЛЭЭР:

“Монголын зохиолчдын “Хурмаст тэнгэр” төвөөс уламжлал болгон зохиодог хайрын шүлгийн “Оюу-Ай” яруу найргийн наадам амжилттай зохион байгуулагдлаа. Яруу найргийн наадамд Улаанбаатар, Дорноговь,Завхан, Дархан, Хөвсгөл, Дархан-уул, Хэнтий, Увс, Сүхбаатар,Говь-Алтай, Дундговь, Төв, Булган аймгуудаас 35 яруу найрагч шүлгээрээ уралдаж:

- Тэргүүн байрт Дорноговь аймгийн яруу найрагч Э.Анхбаяр
- Дэд байрт Хөвсгөл аймгийн яруу найрагч Ш.Бадамрагчаа
- Гуравдугаар байрт Дорноговь аймгийн яруу найрагч О.Алтангэрэл
- Тусгай байрт Булган аймгийн яруу найрагч Г.Хашбаатар
- Тусгай байрт Улаанбаатар хотоос оролцсон яруу найрагч С.Начин нар тус тус шалгарсан.

Соёлын яам болон JCI Монгол төрийн бус байгууллагын Их хүрээ салбараас Дорноговь аймгийн Ерөнхий боловсролын дунд сургуулийн ахлах ангийн 1000 гаруй сурагчдад зориулан "ОЮУНЫ ЭЛЧ-MIND UPDATE" хувь хүний хөгжлийн лекц, сургалтыг зохион байгууллаа.

MIND UPDATE сургалтад:

- 1.Ногоон ирээдүй
- 2.Мэргэжилдээ хэрхэн эзэн болох вэ?
- 3.Сэтгэлгээний өөрчлөлт
- 4.Хайрын 5 хэл
- 5.Тэмүүлэл хүнийг хааш нь хөтөлдөг вэ? сэдвээр лекц, сургалт орлоо.

МУСГЗ Нацагдоржийн шагналт Арлааны Эрдэнэ-Очирын "Хос ном"-ын нээлтэд Соёл урлагийн газрын хамт олон оролцож хүндэтгэл үзүүлсэн.

Дорноговь аймгийн Засаг даргаас Соёл, урлагийн газрын даргатай 2023 онд төлөөлөн гүйцэтгүүлэх, хамтран ажиллах гэрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталлаа.

Дорноговь аймгийн Соёл, урлагийн газрын зөвлөн туслах ажлын баг 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдөр Дэлгэрэх сумын Соёл, спортын төв, Алтанширээ сумын Соёлын төвд ажиллаж байгууллагын үйл ажиллагаатай танилцаж, албан хаагчдыг ажлын байран дээр сургах, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэхэд туслалцаа үзүүлэн зөвлөмж чиглэл өглөө.

Дорноговь аймгийн Мандах сумын Дэнгийн овоо орчмын “Дорнын говь-2022” археологийн малтлага, судалгааны ажлын явцад илэрсэн олдворуудаас 4 ширхэг эд өлгийн зүйлийг музейн үндсэн сан хөмрөгт бүртгэж авсан.

2 дугаар сард 44 том хүн, 237 хүүхэд нийт 281 хүнд музейн үйлчилгээ үзүүлсэн.

Цагаан сарын баярыг угтан зохион байгуулсан “Сар шинийн мэнд” баярын нэвтрүүлэгт Эвийн эгшиг уртын дууны дугуйлангийн 22 суралцагч, Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч 3 уламжлагч оролцов.

Саран хөхөө театр 14 төрлийн үйл ажиллагааг зохион байгуулж, 3655 үзэгчдэд урлаг соёлын үзвэр үйлчилгээг хүргэн ажилласан.

МУСТА Н.Мөнгөншагайгийн Хайрламаар сайхан аялан тоглолтыг 210 гаруй үзэгчид үзсэн.

Нийслэл хүүхний “Бал сар” МУСК-г 900 үзэгч үзсэн.

Дорноговь аймгийн Үйлдвэрчний эвлэлийн хороо театрын бүжиг анги хамтран ажлын байр, эрүүл мэндийн дасгалыг зохион байгуулж шилдгүүдээ тодрууллаа. Нийт 53 албан хаагч, уран бүтээлчид хамрагдсан.

“Инээд бэлэглэх аян” хүүхдийн тоглолтыг 450-н хүүхэд багачууд үзэж сонирхсон.

“Гурван гавьяатын дуулал” аялан тоглолтыг 280 гаруй үзэгч үзсэн.

Саран хөхөө театр байгууллагын 53 албан хаагчид, уран бүтээлчиддээ зориулан “Ажлын байрны стресс бухимдал” сэдвээр сургалт зохион байгууллаа.

Гэгээн хайрын баярт зориулан театрын 40 уран бүтээлчид “Love to live” амьд хөгжмийн тоглолтыг зохион байгуулж 150 гаруй үзэгчдэд толилуулсан. Мөн байгууллагын цахим хуудсанд байршуулсан.

“Зөв бичихийн дүрэм”ийн сургалтыг зохион байгуулж 51 албан хаагч, уран бүтээлчид хамрагдсан.

Сар шинийн баярыг тохиолдуулан олон хүрээ Дэчинчонхорлон хийдтэй хамтран “Шашин урлагийн цэнгүүн” зохион байгуулж 150 үзэгчдэд толилуулсан.

Номын сангаар уншигч-50, ирж үйлчлүүлсэн-354, танхимаар 750 ном олгож, гэрээр 105 ном олгосон. Зөврөөр ном олголт 36, “Аз жаргалын өрөө”-нд 3-р цэцэрлэгийн хүүхэд, багш ажилчид 25 хүн хамрагдсан.

МУСГЗ Нацагдоржийн шагналт Арлааны Эрдэнэ-Очирын “Хос ном”-ын нээлтийн арга хэмжээг Аймгийн номын санд зохион байгуулан ажиллаж нийт 100 гаруй иргэн хамрагдсан.

Хүүхдийн зохиолч Л.Мөнхбаттай хамтран хүүхдүүдэд үлгэр тууль, дэлхийн сонгодог хүүхдийн зохиолоор ярилцлага зохион байгуулан нийт-20 хүүхэд хамрагдсан.

Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан “Миний нандин эрдэнэ” бүтээлийн уралдааныг зарласан.

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ЧИГЛЭЛЭЭР:

Биеийн тамир, спортын газрын жүдо бөх, чөлөөт бөх, бокс, шатар, сагсан бөмбөг, волейболын дугуйлан, шагай харваа, фитнес хэвийн хичээллэн ажиллаж байна.

Нөхөрлөл лигийн тоглолт 2023 оны 02 дугаар сарын 07, 14, 28-ны өдрүүдэд Спорт цогцолборт болов.

БТСГ нь ажил хайгч 5 иргэнийг ажлын байраар ханган ажилласанд аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас ТАЛАРХАЛ авч ажиллалаа.

Спортын ордонд 02 дугаар сарын 04-05-ны өдрүүдэд өсвөрийн аймгийн аварга шалгаруулах шатрын тэмцээн боллоо. Тус тэмцээн 6 хүртэлх, 7-8 нас, 9-10 нас, 11-12 нас, 13-14 нас, 15-16 нас, 17-18 нас эмэгтэй, эрэгтэй гэсэн ангилалаар нийт 42 багц медалийн төлөө 5 сум, 8 клубын 200 гаруй өсвөрийн тамирчид оролцлоо.

Спортын ордонд 02 дугаар сарын 04-ний өдөр Пауэрлифтингийн аймгийн аварга шалгаруулах “Raw classic” нээлттэй тэмцээн болов. Тус тэмцээнд Сайншанд сум, Айраг сум, Замын-Үүд сум, Говь-Сүмбэр аймаг, Өмнөговь аймаг, Улаанбаатар хотын Стронг, SBD, Хангай, Олимп, World gym, Могул зэрэг клубын нийт 67 тамирчин оролцлоо. Тэмцээний багийн нийлбэр дүнгээр О.Ганбилэг ахлагчтай Дорноговь аймгийн баг тэргүүлсэн бол дэд байранд Л.Ариунжаргал ахлагчтай Замын-Үүд сумын баг тамирчид, гутгаар байранд Гантөгс ахлагчтай Могул фитнес клубын тамирчид шалгарсан байна.

Спорт цогцолборт 02 дугаар сарын 04-05-ны өдрүүдэд Дорноговь аймгийн Сайхандулаан сумын харьяат Монгол Улсын Заан Л.Сүрэнжав агсаны нэрэмжит өсвөрийн үндэсний бөхийн барилдаанд 170 гаруй бөхчүүд өрсөлдлөө.

Дорноговь аймгийн зарим сумдын биеийн тамир, спортын 32 албан хаагчидтай уулзах, туршлага судлах, нөхөрсөг тэмцээн зохион байгуулах ажлыг 02 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулж ажиллалаа. Уг уулзалтаар бүтэц орон тоо, хийж хэрэгжүүлсэн ажил танилцуулах, тулгамдаж буй асуудлын талаар ярилаа.

БОЛОВСРОЛЫН ЧИГЛЭЛЭЭР:

Боловсролын ерөнхий газраас ирүүлсэн маягтын дагуу 2022-2023 оны хичээлийн жилд түр болон ажлаасаа чөлөөлөгдөн гадаад явсан ЕБС-ийн багш нарын судалгааг нэгтгэн хүргүүлсэн.

БШУЯам, БҮТ, БСҮХ, БЕГ-аас хамтран зохион байгуулсан “Цэцэрлэгийн багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ ба багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих зөвлөмж” танилцуулах нэгдсэн болон салбар /цахим/ сургалтад БШУГ-ын 3 мэргэжилтэн, эрхлэгч, аргазүйч, багш нар хамрагдсан.

БШУЯ, Дэлхийн банкнаас хэрэгжүүлж буй “Боловсролын чанарын шинэчлэл” төслийн хүрээнд бага ангийн багш нарт 522 ширхэг 7.459.794 төгрөгийн үнэ бүхий Дасгал ажлын дэвтэр ирүүлснийг хуваарилан мэдээллийг төслийн багийнханд цахимаар хүргэсэн.

Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын төгсөгч Б-ТМБ-7-7.2, 3-ТМБ-9-9.3/, тэтгэлэг Б-ТМБ-8, 3-ТМБ-10, Санхүү Б-ТМБ-9, 3-ТМБ-11, 11.1 мэдээг хянан маягтаар гарган хугацаанд нь БЕГ-т хүргүүлсэн.

БШУ-ны сайдын 2022 оны А/545 дугаар тушаалаар баталсан багшийн мэргэжлийн ёс зүйн дүрэм, ёс зүйн зөвлөлийн ажиллах журмын хэрэгжүүлэх чиглэл, зөвлөмж цахим уулзалтад 2 сарын 3-ны өдөр СӨБ, ЕБС хариуцсан мэргэжилтнүүд хамрагдлаа.

2022 оны санхүүгийн жилийн эцсийн тайланд хийх аудитад 54 байгууллагаас 47байгууллагад хяналт шалгалт хийгдээд дуусч байна.

12-р ангийн сурагчдын дунд математикийн судлагдахуунаар "Дэвжээ-2023-2" тэмцээнийг Зүүнбаян ЕБСургууль зохион байгуулж, 9 сургуулийн 20 бүлгийн 200 гаруй сурагч, 30 багш хамрагдлаа.Уг арга хэмжээний үед бүх сурагчдаас ЭЕШ-н сорилго авч, МУ-ын Зөвлөх болон тэргүүлэх зэрэгтэй 5 багш сургалт явуулж, сурагчдын дунд өртөөчилсөн бодлогын уралдаан зохион байгууллаа.

10 сургуулийн 22 бүлгийн сурагчдаас математик, физикийн судлагдахуунаар ЭЕШ-урьдчилсан сорил авч, дүн мэдээг нэгтгэн сургуулиудад хүргүүлсэн.

2021 оны Засгийн газрын 372 тогтоолоор баталсан “Бүх нийтийн англи хэлний суралцахуйг дэмжих арга хэмжээ (2022-2025)”-ний 4.3.2 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгын хүрээнд Ерөнхий боловсролын сургуулийн англи хэлний сургалтын хөтөлбөр, арга зүй, үнэлгээг сайжруулах зорилгоор Английн “PEARSON” олон улсын англи хэлний сургалтын хөтөлбөрийг улсын хэмжээнд 38 сургуулийн 5-9 дүгээр ангийн сурагчдад 2023 оны 02 сарын 01-с туршин хэрэгжүүлж эхэллээ. Тус хөтөлбөрийн туршилт Сайншанд сумын 1-р сургуульд 5-9-р ангийн 943 сурагчид хэрэгжихтэй холбоотойгоор 02 сарын 06-08-ны өдрүүдэд сургуулийн 84 багш, ажилтан, 5-9-р ангийн 186 эцэг эх, асран хамгаалагчдад хөтөлбөрийн танилцуулга хийж, зөвлөмж , мэдээлэл өгөв.

Багш нарын ажлын байран дээр мэдлэг боловсролоо дээшлүүлэх, харилцан бие биеэсээ суралцах ажлын хүрээнд дүгнэлт, хэлэлцүүлэг хийж сургалт зохион байгуулсан удирдлага, багш нартаа батламж гардуулж дараагийн үйл ажиллагааг

Мэргэжлийн Хөгжлийн Бүлгээрээ чанартай зохион байгуулж дүгнэлт хэлэлцүүлэг хийж ажиллалаа.

Миний монгол хэл, бичиг-2025 хөтөлбөрийн хүрээнд “Мэргэжлийн хөгжлийн бүлгээрээ судалъя, хөгжье” монгол хэлний хэлц үгийн утгын оновчтой тайлбар, оньсогын хариултыг нэгтгэн дүгнэж, эхний 3 байрыг шалгаруулж урамшууллаа.

БШУЯ, Дэлхийн банкнаас хамтран хэрэгжүүлж буй "Боловсролын чанарын төсөл"-ийн хүрээнд бага ангийн багш нарт "Бие даан ажиллах дасгал ажлын дэвэр" ирснийг сургуулиудад хуваарилан тараасан

БШУГ-аас Алтанширээ, Дэлгэрэх, Иххэт сумын ерөнхий боловсролын сургуулиудын үйл ажиллагаатай танилцаж, сургууль, цэцэрлэгийн хамт олонд “Багаар ажиллах чадвар”, “Идэвхтэй сургалтын арга зүй”, “Сургуулийн менежмент”, “Боловсролын цаг үеийн мэдээлэл” сэдвээр сургалт, дадлага хосолсон хэлэлцүүлгийг зохион байгуулж багш нартай санал солилцлоо. Сургалтад сургууль, цэцэрлэгийн 89 багш, ажилтан хамрагдсан.

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР:

Ажилд зуучлагдсан иргэдийн тоо: 26 буюу 18 хувиар өссөн

Шинэ ажлын байрны тоо: Шинэ ажлын байр бүртгэгдээгүй

Бүртгэлтэй ажил хайгч иргэдийн тоо: 241 буюу өмнөх оны мөн үеийнхээс 49 хувиар багассан.

Ажлын байрны захиалга: 66 буюу өмнөх оны мөн үеийнхээс 22 хувиар өссөн байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгоход урьдчилсан байдлаар дүгнэлт гаргах ажлын хэсгийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын даргын А/05 дугаар тушаалаар байгуулан ажиллаж Зээлийн өмнөх сургалтыг “BEST” сургалтын төвтэй хамтран 01 дүгээр сарын 30, 02 дугаар сарын 07-ны өдөр зохион байгуулж нийт 62 иргэн сургалтад хамрагдсан. 2023 оны 02 дугаар сарын 06,14-ний өдрүүдэд 2 удаа хуралдаж нийт 43 иргэн, 4 аж ахуйн нэгжийн төслийг хянан үзэж, Монгол улсын Засгийн газрын 2021 оны 340 дүгээр тогтоолоор батласан “Хөдөлмөр, эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл, олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-ын шаардлага хангасан 43 төслийг дэмжиж дараагийн шатны байгууллагад дүгнэлтийг хүргүүлж 4 төслийг шаардлага хангаагүй төсөл гэж үнэлж дүгнэж ажилласан.

45 ААНБ-аас 69 ажлын байрны захиалгыг авч, ХХҮГ-ын вэйб хуудас, ажил хайгч иргэдийн нэгдсэн групп, байгууллагын угтах зааланд хөлтэй слайданд байршуулан, тохирох мэргэжлийн ажил хайгч иргэд рүү утсаар холбогдон санал тавьж сонирхсон иргэдийн анкетыг хүлээн авч ажилласан.

1ААНБ-д 1 иргэнийг зуучилсан.

Хамтран ажиллах гэрээ 12 ААНБ байгуулсан байна.

Залуучуудын загвар төвөөр үйлчлүүлсэн нийт иргэдийн тоо: 292 иргэн Үүнд:

- Ажилгүйдлийн тодорхойлолт: 15 иргэн
- Загвар төвөөр үйлчлүүлэн мэдээлэл авсан болон ажил хайсан: 10 иргТүр болон цагийн ажлын байрны захиалга: 2 аж ахуйн нэгж, 2 ажлын орон тоонд захиалга авч 1 иргэнийг зуучлан ажилласан.

"Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ"-г Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 9,11,12 дугаар ангийн нийт 267 сурагчдад үзүүлж, хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын үйл ажиллагааг танилцуулсан.

2023 оны 2 дугаар сарын 8 ний өдөр Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 9-12 дугаар ангийн 50 сурагчдад, 2 дугаар сарын 9 ний өдөр, 5 дугаар сургуулийн 60 сурагчдад тус тус Мэргэжил сонголтын талаарх сургалтыг зохион байгуулан ажилласан.

2023 оны 2 дугаар сарын 15 ний өдөр Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн дотуур байрны 10-12 дугаар ангийн 50 сурагчдад мэргэжил сонголтын талаар сургалт мэдээлэл хийж ажилласан.

Хөдөлмөр эрхлэлтийн цахим систем EJOB платформыг танилцуулах сургалтыг 2023 оны 02 дугаар сарын 01-03-ны өдрүүдэд Сайншанд суманд үйл ажиллагаа явуулж буй төр, хувийн хэвшлийн ажил олгогч байгууллагуудад зохион байгуулж, 91 байгууллагын 130 удирдлага, хүний нөөцийн ажилтнууд хамрагдсан. Сургалтын үр дүнд: 117 байгууллага EJOB платформ-д ажил олгогчоор бүртгүүлж, 69 сул чөлөөтэй ажлын байрны захиалгыг оруулан ажилласан.

EJOB платформыг ажил олгогчид зориулан гарын авлага бэлтгэж 100 ширхгийг тараан ажилласан.ejob.gov.mn программын сургалтын зар, шторк хийж байгууллагын пэйж хаяг, орон нутгийн DTV телевизэд мэдээллийг иргэдэд өгч ажилласан.

Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний загвар төв болон цагийн ажлын зар авах, цагийн ажилд зуучлах,ажил хайгч болон хувиараа бизнес эрхлэх хүсэл эрмэлзэлтэй залуучуудад зориулсанүе шаттай модуль сургалтын талаар мэдээ мэдээлэл өгч байгууллагын пэйж хуудсаар шууд лайв дамжуулж 585 хандалт авсан.

2023 оны 02 дугаар сарын 16 ний өдөр Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар зөвлөлийн дарга, нарийн бичиг нарыг чадавхжуулах сургалтыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, Эрүүл мэндийн төв, Аймгийн засаг даргын тамгын газартай хамтран зохион байгуулсан. Сургалтад сумдын салбар зөвлөлийн дарга, нарийн бичиг нийт 29 ажилтан албан хаагч оролцож сертификатаа гардан авлаа. Уг сургалтаар Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Салбар зөвлөлийн чиг үүрэг, тулгарч буй асуудал, 2023 онд Хөдөлмөрийн аюулгүй байдалын хүрээнд хэрэгжих төсөл хөтөлбөрүүдийн талаар Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл мэндийн төвийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хэлтсийн дарга доктор, профессор Н.Энхтайван мэдээлэл арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

2022 оны 1 дүгээр сарын 5-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар “Хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох журам”, “Өрхийн мэдээллийн нэгдсэн санг удирдах, ашиглах, хадгалах, түүний аюулгүй байдлыг хангах журам”-ын дагуу өрхийн засварласан мэдээллийг 02 дугаар сарын 08-ны 17 цагаас 02 дугаар сарын 15-ны өдрүүдэд бодолт хийгдэж хүүдийн мөнгөнд хамрагдах эсэх мэдээлэлийг шинэчилсэн бөгөөд үүний дүнд 02 дугаар сарын хүүхдийн мөнгөн тэтгэмжийн жагсаалтыг 24117 хүүхдэд үүсгэж банкруу илгээлээ. Энэ нь 2022 оны 12 дугаар сард олгосон хүүхдийн тоотой харьцуулахад 91 хувьд олгогдсон байна. Дээрх журмын хүрээнд Аймгийн засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн А/82 тоот захирамжаар байгуулагдсан хамтарсан багт 01 дүгээр сард хүүхдийн мөнгөнд хамрагдаагүй 2220 хүүхдийн мэдээллийг сумдаар нэгтгэн гаргаж өгөв.

И халамж нэгдсэн системээр халамжийн үйлчилгээнд хамрагдах хүсэлтээ гаргасан 2477 иргэний хүсэлтийг хүлээн авч хугацаанд нь шийдвэрлэснээс гадна биеэр болон утсаар хандсан 447 иргэнд үйлчилгээ үзүүлсэн.

2-р сарын тэтгэвэр, тэтгэмжийн олголтыг иргэдийн дансруу илгээлээ. Үүнд:

- Цалинтай ээжийн тэтгэмж 2744 иргэнд 131,4 сая төгрөг
- Жирэмсэн эхийн тэтгэмж 507 иргэнд 18,1 сая төгрөг
- Насны хишиг 3098 иргэнд 246,5 сая төгрөг
- Алдарт эхийн одонгийн тэтгэмж 5347 иргэнд 678,7
- Халамжийн тэтгэвэр 1295 иргэнд 365,6 сая төгрөг
- Асаргааны тэтгэмж 1030 иргэнд 92,3 сая төгрөг
- Амьжиргаа дэмжих мөнгөн тэтгэмж 270 иргэнд 72,5 сая төгрөг
- Ихэр хүүхдийн мөнгөн тэтгэмж 2 иргэнд 4,0 сая төгрөг
- Ахмад настны хөнгөлөлт тусламж 3724 ахмадад 43,1 сая төгрөг
- Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх хөнгөлөлт тусламж 87 иргэнд 10,1 сая төгрөг
- Онцгой тохиолдлын тэтгэмж 1 иргэнд 1,2 сая төгрөг
- Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээг 158 өрхийн 302 том хүн, 409 хүүхдэд 8,7 сая төгрөг
- Хүүхдийн мөнгөн тэтгэмж 2, 3-р сарын хүүхдийн мөнгөнд 24117, нийт 4,823.4 сая төгрөг нийт 42933 иргэнд 6,495.6 сая төгрөг олгосон.

Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаатай холбоотой өргөдөл хүлээж аваагүй.

Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаанд 01 дүгээр сард хамрагдсан иргэдийн зөрүүтэй мэдээллийг өрхтэй холбогдож баталгаажуулан 2023 оны 02 дугаар сарын 08-ны 95 тоот албан бичгээр Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газарт хүргүүлэв

Хүнсний эрхийн бичигээр үйлчилдэг 6 дэлгүүрийн иргэдэд үйлчилгээ үзүүлж байгаа байдалд хяналт тавьж ажилласан. Дээрх дэлгүүрүүдэд хүнсний эрхийн бичигээр үйлчилгээ үзүүлэх барааны жагсаалт байхгүй байсан тул мэдээллийн самбарт байрлуулах талаар зөвлөмж өгсөн. Бараа таталт хэвийн, хориотой бүтээгдэхүүн худалдан авсан зөрчил илрээгүй.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын хурлыг батлагдсан хуваарийн дагуу 02.07 өдөр зохион байгуулж 16 хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй эсэх болон байнгын асаргаа шаардлагатай эсэх асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн.

ФХВ төсөлд хамрагдаж буй Сайншанд сумын 25 өрхийн уулзалтанд олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний бүлгийн төслийн талаарх мэдээлэл хүргэн тэдний сонирхсон асуултанд хариулт өгч ажилласан.

“Халамжаас хөдөлмөрт-222” арга хэмжээний хөтөлбөр төлөвлөгөөг боловсруулан батлуулж 02 сарын 07 өдөр зохион байгуулсан. Тус арга хэмжээнд уналт таталт эпилепси оноштой хөгжлийн бэрхшээлтэй байнгын асаргаатай хүүхдийн эцэг эх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нарийн мэргэжлийн эмчийн зөвлөгөө, хөдөлмөр халамжийн чиглэлээр хэрэгжиж буй төсөл арга хэмжээний талаар мэдээлэл танилцуулгыг өгч ажилласан.

Мөн тус өдөрлөг арга хэмжээний хүрээнд олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний бүлгийн төслөөс дэмжлэг авсан Сайншанд сумын 4 бүлгийн иргэд өөрсдийн үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдааг гаргаж иргэдэд танилцуулан 80,000 төгрөгийн борлуулалт хийсэн.

Сайншанд сумын Амьжиргаа дэмжих зөвлөлийн хурлыг зохион байгуулж 21 иргэний өргөдлийн дагуу өрхүүдээр зочилж нөхцөл байдлын үнэлгээ хийсэн бөгөөд холбогдох баримт материалд үндэслэн 19 иргэний өргөдлийг бүрэн шийдвэрлэж 2 иргэний хүсэлтийг дахин нягтлахаар хойшлуулсан.

ДӨРӨВ. САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТЭС

Зорилтод арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн явц:

- Улсын төсвийн байгууллагуудын тогтмол зардлын санхүүжилтэд 1.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон.
- Орон нутгийн төсвийн байгууллагад 1.3 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон.
- Орлогын төлөвлөгөө 1 дүгээр сарын байдлаар 7.8 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээс гүйцэтгэлээр 3.2 тэрбум төгрөгийн орлого төвлөрч 4.6 тэрбум төгрөгөөр орлого тасарч 41.1 хувийн биелэлттэй гарсан.
- Хэлтсийн төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтнүүд 2023 оны 02 сарын 28-ны хооронд нийт 1456 гүйлгээний 13.7 тэрбум төгрөгийн төлбөр тооцоог төлбөрийн хүсэлт, хяналтын хуудас анхан шатны баримтын бүрдлийг хянаж Засгийн газрын санхүүгийн удирдлага мэдээллийн системээр дамжуулан ажилласан.
- Ахмадын сангийн 67 байгууллагын хүсэлтийг үндэслэн 120.8 сая төгрөгийн нэмэлт төсвийн зарцуулах эрхийг нээж ажилласан.
- Нэмэлт санхүүжилтийн 45 байгууллагын хүсэлтийг үндэслэн 568.9 сая төгрөгийн зарцуулах эрхийг нээж ажилласан.
- Орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны төсвийн жилийн зарцуулалтын тайланг нэгтгэн Сангийн яаманд хүргүүлсэн.

- Төрийн албаны цалингийн нэгдсэн системд шинээр томилогдсон 5 байгууллагын дарга, 7 нягтлан бодогчийн хүсэлтийг үндэслэн баталгаажуулан ажилласан.
- Шинээр байгуулагдсан 8 аж ахуйн нэгж байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээг үндэслэн e-balance системд бүртгэн анхаарах асуудлуудын талаар нягтлан бодогчид заавар, зөвлөгөө өгч ажилласан.
- Айраг сумын Эрүүл мэндийн төвөөс ирүүлсэн хүсэлтийг үндэслэн Ахмадын сангийн данс шинээр нээлгэх албан бичгийг Сангийн яамны Төрийн сангийн газарт хүргүүлж төрийн санд бүртгэлийн дансыг нээлгэж ажилласан.
- Сайншанд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 11/05 тогтоолоор Тохижилт Сайншанд хот тохижилтын газрыг татан буулгасантай холбогдуулан төрийн сангийн харилцах дансуудыг хаалгах хүсэлтийг Сангийн яаманд хүргүүлж дансыг хаалгасан.
- Политехникийн коллеж Боловсрол шинжлэх ухааны харьяа байгууллага болж төрийн санд бүртгэлийн данс шинээр нээгдсэн тул ашиглагдахгүй байгаа дансуудыг хаалгах хүсэлтийг Сангийн яаманд хүргүүлэн хаалгасан.
- Аймгийн 2023 оны 2 дугаар сарын төсвийн хуваарьт өөрчлөлт оруулж, төсвийн баазыг Сангийн яаманд хүргүүлэн татуулсан.
- МАСАМ II төслийг орон нутагт хэрэгжүүлж төсвийн ил тод байдлыг хангах ажлын хэсэг хуралдаж хийх ажлын төлөвлөгөөг гаргасан.
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5 дахь заалтын дагуу 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг И-Баланс системд 86.1 хувьтай нэгтгэн хүлээн авсан.
- Төрийн сангийн цахим удирдлагын системд онлайнаар төлбөр тооцоог хийж байгаатай холбогдуулан сумд болон аймгийн төвийн байгууллагуудын нягтлан бодогчдод мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна.

Санхүүгийн хяналт, аудитын алба:

Зорилтот арга хэмжээний хэрэгжилтийн явц.

- Аймгийн Засаг даргын баталсан 2023 оны санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитын нэгдсэн удирдамж, төлөвлөгөөний биелэлтийг ханган ажиллаж байна.

Цаг үеийн ажлын мэдээлэл:

- Санхүүгийн хяналт дотоод аудитын албаны даргын баталсан удирдамжаар Сайншанд сумын 6 дугаар цэцэрлэг, 3 дугаар цэцэрлэг, 1 дүгээр цэцэрлэг, 2 дугаар цэцэрлэг, 5 дугаар цэцэрлэгийн 2021-2022 оны санхүүгийн болон бусад үйл ажиллагаанд төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийж байгууллагын нийт албан хаагчдын дунд шалгалтын дүнгийн хурлыг ил тод нээлттэй хийсэн.
- Албаны даргын 07 тоот удирдамжаар аймгийн Нэгдсэн эмнэлэгийн 2021, 2022 оны санхүү аж ахуй болон бусад үйл ажиллагаанд сэдэвчилсэн хяналт шалгалтыг хийж байна.
- Сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дотоод ажил хариуцсан мэргэжилтнүүдэд зориулж нягтлан бодох бүртгэлийн анхан шатны

баримтын бүрдүүлэлт сэдвээр 2023 оны 02 дугаар сарын 7-ны өдөр сургалт зохион байгуулсан.

- Актын төлбөрийн үлдэгдлээс 1,5 сая төгрөгийг барагдуулж орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлсэн.
- Албаны даргын баталсан удирдамжаар Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Байгаль орчин аялал жуучлалын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар зэрэг байгууллагуудын 2021-2022 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийж гүйцэтгэж байна.
- Сайншанд сумын 6 дугаар цэцэрлэг, 3 дугаар цэцэрлэг, 1 дүгээр цэцэрлэг, 2 дугаар цэцэрлэг, 5 дугаар цэцэрлэгийн санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын нэгдсэн акт, тэмдэглэлийг эцэслэн боловсруулж байна.

Татварын хэлтэс:

Зорилтот арга хэмжээний хэрэгжилтийн явц.

- Улс ба орон нутгийн төсөвт 2921,6 сая төгрөгийн татварын орлого төвлөрүүлсэн.
- Тайлант хугацаанд цахим татварын мэдээллийн шинэ системийг хэрэгжүүлэн 5 төрлийн нийт 1367 татварын тайлан, 939 хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэн ажилласан. Сарын хугацаанд 70521288 нэгдсэн дуудлагын дугаараар 784 татвар төлөгчдөд Татварын хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын систем, Цахим татварын мэдээллийн шинэ системийн заавар зөвлөгөө сурталчилгааг хийсэн. Татварын үйлчилгээ үзүүлэх 18001288 дугаарын утсаар 2145 татвар төлөгчдөд зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.
- Татвар төлөгчдөөс 1800-1288 тусгай дугаарт ирүүлсэн 13 гомдлыг хуваарилж, 17 гомдлыг шийдвэрлэж баталгаажуулсан.
- Аймгийн Улсын бүртгэлийн хэлтсээс шинээр үүссэн байгуулагдсан 7 хуулийн этгээдийн мэдээллийг татварын нэгдсэн удирдлагын системд бүртгэж, Нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчөөр 8 хуулийн этгээдийг бүртгэсэн.
- Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тайланг 98,6 % -тай, Хувь хүний орлогын албан татварын тайланг 55,1%-тай хүлээн авсан.
- Татвар төлөгч нарт Хувь хүний орлогын албан татварын, чөлөөлөлт, буцаан олголтын талаар 5 удаагийн сургалт зохион байгуулж, асуултад хариулт өгч ажиллалаа.

Статистикийн хэлтэс:

Зорилтод арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн явц:

- Аймгийн нийгэм, эдийн засгийн 2023 оны 1 дүгээр сарын танилцуулгыг боловсруулж, хэлтсийн цахим хуудас болон фэйсбүүк хуудсанд байршуулан, 600 гаруй хэрэглэгчдэд цахимаар, тархаасан.
- Гол нэр төрлийн 32 бүтээгдэхүүн болон нэмэлтээр 54 нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний үнийг долоо хоног бүрийн даваа гаригт Сайншанд сумын

хүнсний зах, дэлгүүрээс судалж, мэдээний PPI програмд шивэн, хугацаанд нь ҮСХ-нд дамжуулсан.

- Сар бүрийн 27-нд хэрэглээний үнийн 313 нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний үнийг аймгийн төвийн хүнсний зах, дэлгүүрээс судалж программд шивэн, хугацаанд нь ҮСХ-нд дамжуулсан. Мөн Айраг, Даланжаргалан, Эрдэнэ, Замын-Үүд, Хатанбулаг сумдын мэргэжилтнүүд 145 нэр төрлийн бараа бүтээгдэхүүний үнийг программд шивж ҮСХ-нд дамжуулав.
- Аж үйлдвэрийн сарын мэдээ /АҮ-1/, зочид буудал, зоогийн газрын үйл ажиллагааны сарын мэдээ /А-ЗГ-1, А-ЗБ-1/, тээврийн хэрэгслийн тоног төхөөрөмжийн импортын үнийн судалгаа/ТХХТИҮ/, худалдааны салбарын /ХСҮ/, авто усан замын тээврийн улирлын мэдээ /Т-1/ Мэдээлэл харилцаа холбооны улирлын /МХХ-3, МХХ-4, МХХ-6, МХХ-7/ мэдээг, хөдөө аж ахуйн /ХАА-2, ХАА-3, ХАА-10/ мэдээг сум, аж ахуйн нэгж, иргэдээс цуглуулан нэгтгэн нягтлан шалгаж, программд шивж дамжуулсан. Төрийн бус байгууллагын улирлын мэдээ/ТББ/, Мал эмнэлгийн улирлын /МЭ-1/, барилга байгууламж, объектийн улирлын мэдээ /ББО/, аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн улирлын мэдээ /АЖ/-г графикт хугацаанд нь дамжуулан ажилласан.

ТАВ. ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТЭС

- Дорноговь аймгийн Сайншанд хотын VI багт 640 хүүхдийн багтаамжтай ерөнхий боловсролын зургаадугаар сургууль энэ сарын 10-нд ашиглалтад орлоо.
- Шинэ сургууль мэргэжлийн боловсон хүчнээр бүрэн хангагдсан бөгөөд орчин үеийн стандартад нийцсэн хичээл, сургалтын танхим, тусгай хэрэгцээт хүүхдэд зориулсан шат, багш, хүүхэд хөгжлийн төв, мэдээллийн танхим, хичээлээс гадуурх сонгон, дугуйлан, секц, давтлага зохион байгуулах тохилог өрөө танхимтай, зургаан настай хүүхдүүдэд зориулсан өдөр өнжүүлэх танхимыг бүрдүүлснээрээ онцлогтой.
- 2023 онд батлагдсан нийт 99 төсөл арга хэмжээнээс 22 төсөл арга хэмжээ буюу 22,2 хувийн тендерийг цахимаар зарласан. /аймгаас 16, сумдад эрх шилжсэн хөрөнгө оруулалтын ажлуудаас 6 /
 - 2023 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний тендер зохион байгуулах Үнэлгээний хороо байгуулах тухай 19 захирамжийг батлуулсан.
 - Орон нутгийн хөрөнгө оруулалтын 1 төсөл арга хэмжээний 592,3 сая төгрөг, Барьцаа хөрөнгийн данснаас 2 ажилд 58,8 сая төгрөгийн санхүүжилтийн эрхийг нээсэн.
 - Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар үргэлжлүүлэн хийгдэж буй 3 төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг /pimis.publicinvestment.gov.mn/ программд шивж, санхүүжилтийн хүсэлтийг баталгаажуулсанаар, Сангийн яамнаас 4,4 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдсэн байна.
 - Аймгийн Засаг дарга Сумдын Засаг дарга нар болон агентлагын дарга нартай байгуулах гэрээний төслийг ТЗУХ-т өгсөн.

- XVII дугаар жарны "Үзэсгэлэн болгогч" хэмээх харагчин туулай жилийн сар шинийн баярыг угтан уламжлал болгон зохион байгуулдаг "Цагаан сар-2023" үзэсгэлэн худалдааг 2023 оны 02-р сарын 11-12-ны өдрүүдэд 15 дахь жилдээ зохион байгуулсан. Үзэсгэлэн худалдаанд нийт төрийн 12 байгууллага, 115 ААНБ, иргэн, 1 банк санхүүгийн байгууллага оролцож бараа бүтээгдэхүүнээ танилцуулсан.

“Цагаан сар-2023” үзэсгэлэн худалдаанд 8 номинацид шилдэгүүдийг шалгаруулсан. Үүнд :

1. “Шилдэг өрхийн үйлдвэр эрхлэгч”- ээр Даланжаргалан сумын иргэн Т.Цэрэнбаатар
 2. “Шилдэг жижиг дунд үйлдвэр эрхлэгч”- ээр Сайншанд сумын Дэлгэрэх бадам салон
 3. “Шилдэг сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч”- ээр Иххэт сумын иргэн Х.Уугандулам
 4. “Шилдэг мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэгч”-ээр Сайншанд сумын Суман зурхай ххк
 5. “Шилдэг гурил, гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэгч”-ээр Өргөн сумын иргэн Б.Мөнхтуяа
 6. “Шилдэг сав баглаа боодол нэвтрүүлэгч”-ээр Иххэт сумын иргэн Д.Туяа
 7. “Шилдэг шинийг санаачлагч”-аар Сайншанд сумын Далт мөнгөн шанд ххк
 8. “Шилдэг сум”-аар Дорноговь аймгийн Сайншанд сум
- “Аймгийн хошой аварга малчин”, “Аймгийн аварга малчин”, “Аймгийн аварга тэмээчин”, “Аймгийн аварга саальчин” цол, тэмдгээр шагнагдсан Хатанбулаг, Мандах, Сайншанд, Айраг, Даланжаргалан, Дэлгэрэх, Алтанширээ, Иххэт сумдын малчдын шагналыг бэлтгэж хүргүүлсэн.
 - Дорноговь аймгийн Сайншанд сумын 2 дугаар баг хилэнцтэй хөшөөний 3 замын уулзварт 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулах "Их говийн тэмээ-2023" тэмээний наадмын захирамж, удирдамж, хөтөлбөр, төлөвлөгөө, зардлын тооцоог боловсруулсан.
 - Малчдын зөвлөгөөн-2023 арга хэмжээний бэлтгэл ажлыг хангаж ажилласан.
 - *Монгол Улсын Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах “11-11” төвд Замын-Үүд хилийн боомт хэвийн ажиллаж эхэлсэнтэй холбоотойгоор Замын-Үүд суманд том оврын тээврийн хэрэгслийн урт дараалал үүсч, иргэд, зорчигчдод хүндрэл учруулж байгаа тухай 9 иргэний гаргасан гомдлын дагуу Замын-Үүд сумын Засаг дарга, Дорноговь аймаг дахь хилийн боомтын захиргаа, “Автотээврийн үндэсний төв”-д тус тус чиглэл хүргүүлсэн.*
 - Дорноговь аймгийн нийт малчин өрхөд 530тн өвс, 232.7тн тэжээл тус тус татан авах ажлыг хэрэгжүүлсэн.

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР